

**Долоо.** Сумын 2020 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай:

1. Сумын татварын болон татварын бус орлого 911,262.6 мянган төгрөг;
2. Аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 774,245.6 төгрөг,
3. Сумын төсөвт Аймгийн төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг **2,224,743.0** мянган төгрөг;
4. Сумын орон нутгийн хөгжлийн санд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг 981,214.7 мянган төгрөг,
5. ОНХСангийн шилжих үлдэгдэл 31,447.47 мянган төгрөг
6. Орон нутгийн хөгжлийн санд олгох олон улсын байгууллагын урамшуулал 147,895.0 мянган төгрөг
7. Сумын орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдэл 144,889.7 мянган төгрөг

**Найм.** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн 1,160,557.2 төгрөгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, 2020 оны төсвийн жилд хийгдэх “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт”-ийг гуравдугаар хавсралтаар, Сум хөгжүүлэх сангийн зарлагын хэмжээг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

**Ес.** Сумын 2020 оны төсөвт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс гарсан саналыг тусган хэрэгжүүлж, батлагдсан төсвийн орлого, зарлагыг жигд ханган биелүүлж, зарцуулалтад нь хяналт тавьж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2020 оны төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлэх ажиллахыг сумын Засаг дарга /Г.Атархишиг/-д даалгасугай.

**Арван .** Энэ тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч төсөв эдийн засгийн хороо /Ж.Баяраа/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Н.ГАНБААТАР